



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Эдийн засгийн эрх чөлөөний тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.
- 2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

Засгийн газрын 2026 оны 08 дугаар

сарын 05-ны өдрийн 329 дүгээр

тогтоолын хавсралт

**ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
I.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд			
"Once only" буюу бизнес эрхлэгчээс нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлэх:	2027 он	Эдийн засаг, хөгжлийн яам,	Төрийн бүх шатны байгууллага
Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн зохицуулалт зөрчилдөж байгаа эсэхэд шинжилгээ хийж, санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 он	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Эдийн засаг, хөгжлийн яам
Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж буй захиргааны хэм хэмжээний актын үр дагаварт шинжилгээ хийж, шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг хүчингүй болгох	2026 он	Хууль зүй, дотоод хэргийн яам	Эдийн засаг, хөгжлийн яам
Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж буй стандартын үр дагаварт шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг хүчингүй болгох	2026 он	Монгол Улсын Шадар сайд /стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн/	Стандарт, хэмжил зүйн газар
Бизнесийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийхэд баримтлах зарчим, аргачлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 оны 09 дүгээр сар	Эдийн засаг, хөгжлийн яам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Хуулиар тогтоогоогүй бизнес эрхлэгчийн ашиг, орлого, хөрөнгөд ногдуулж байгаа татварыг судалж, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 он	Сангийн яам	Төрийн бүх шатны байгууллага
Худалдан авах ажиллагааны цахим системд хиймэл оюун нэвтрүүлж, хиймэл оюунд суурилан худалдан авах ажиллагааг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх	2026 он	Монгол Улсын Шадар сайд	Төрийн худалдан авах ажиллагааны газар
Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж байгаа эсэх, тендер шалгаруулалтын баримт бичиг, ажлын даалгавар нь өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, үүссэн зөрчлийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Тухай бүр	Монгол Улсын Шадар сайд /шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал эрхэлсэн/	Монополын эсрэг газар
Цахим бизнес эрхлэгчийн бүртгэл хөтлөх, бүртгэлийн дугаар олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 оны 09 дүгээр сар	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Сангийн яам
Бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэх боломжийг бүрдүүлэх	2026 оны 08 дугаар сар	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх	Тухай бүр	Төрийн бүх шатны байгууллага	Эдийн засаг, хөгжлийн яам
Монгол Улсын стандартыг төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлж, бизнес эрхлэгч болон хэрэглэгчдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн үйлчилгээний нэгдсэн системд байршуулах	2026 он	Монгол Улсын Шадар сайд /стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн/	Стандарт, хэмжил зүйн газар
Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийн явцын тайланг бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулах	2027 оны 06 дугаар сар	Эдийн засаг, хөгжлийн яам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

1	Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөө, бизнес эрхлэх орчин, зохицуулалтын чанарыг үнэлэх олон улсын индексийн үнэлгээг сайжруулах санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах	2026 он	Эдийн засаг, хөгжлийн яам	Бүх яам
	Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах	Тухай бүр	Эдийн засаг, хөгжлийн яам	Төрийн бүх шатны байгууллага
II.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд				
1	Бүх зөвшөөрлийг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим системээр дамжуулан олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэдэгдэл хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	2026 он	Эдийн засаг, хөгжлийн яам,	Төрийн бүх шатны байгууллага, "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ
1	Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй болох нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тохиолдолд зөвшөөрлийг ажлын 2 өдөрт сунгах	Тухай бүр	Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Төрийн бүх шатны байгууллага
1	Зөвшөөрөл олголт, сунгалт, хугацааны талаарх мэдээллийг байгууллага бүрээр гаргаж олон нийтэд нээлттэй мэдээлэх, Засгийн газрын хуралдаанд танилцуулах: • Зөвшөөрөл авах, сунгуулахаар гаргасан хүсэлтийн тоо; • Хүсэлтийг шийдвэрлэж олгосон, сунгасан зөвшөөрлийн тоо; • Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан тоо, үндэслэл; • Түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн тоо; • Зөвшөөрөл олгох, сунгах хугацааны хэтрэлтийн талаарх мэдээлэл түүний үндэслэл.	2026 оны 08 дугаар сар	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагууд
1	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох	2026 он	Хууль зүй, дотоод хэргийн яам	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
2	Зөвшөөрөл, мэдэгдлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрөл, мэдэгдлийг хүргүүлэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой журмыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 оны 09 дүгээр сар	Эдийн засаг, хөгжлийн яам	-
2	Зөвшөөрлийн зөвлөлийг байгуулах	2026 оны 09 дүгээр сар	Эдийн засаг, хөгжлийн яам	-

2	Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэхээс өмнө эрх бүхий этгээдэд хүргүүлэх баримт бичгийн жагсаалтыг батлах	2026 оны 09 дүгээр сар	Эдийн засаг, хөгжлийн яам, Зөвшөөрлийн зөвлөл	Зөвшөө рөл олгох эрх бүхий байгууллага
2	Зөвшөөрөл, түүнтэй холбоотой үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зөвшөөрлийн зөвлөлд танилцуулах	2027 он	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Зөвшөө рөл олгох эрх бүхий байгууллагууд
2	Зөвшөөрлийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн зорилгоо алдсан, давхардсан, үр ашиггүй зөвшөөрлийг хүчингүй болгох талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2027 он	Эдийн засаг, хөгжлийн яам, Зөвшөөрлийн зөвлөл	Зөвшөө рөл олгох эрх бүхий байгууллагууд
2	Эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд энгийн зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцох зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах	2026 оны 08 дугаар сар	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Зөвшөө рөл олгох эрх бүхий байгууллагууд
2	Зөвшөөрлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар олон нийтэд сурталчлан таниулах	Тухай бүр	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	-
III.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд				
2	Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт хийх хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх журмыг батлах	2026 оны 11 дүгээр сар	Эдийн засаг, хөгжлийн яам	Бүх яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
2	Гаалийн тариф, гаалийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх барааны жагсаалтыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах	2026 оны 09 дүгээр сар	Сангийн яам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
2	Гадаадын банк байгуулахтай холбоотой тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, баримт бичгийн жагсаалт болон холбогдох журмыг хуулийн шинэ зохицуулалтад нийцүүлэн шинэчлэх	2026 он	Эдийн засаг, хөгжлийн яам	Монгол банк
3	Санхүүгийн байгууллагын татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод ногдуулах 5 хувийн албан татварын зохицуулалтыг татварын бүртгэл, тайлагналын системд тусгах	2026 он	Сангийн яам	Санхүүг ийн зохицуулах хороо

3	Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоо, чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэх	2026 оны 08 дугаар сар	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	Монгол Улсын Шадар сайд
3	Хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, дэмжих цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж танилцуулах	2026 оны 09 дүгээр сар	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	Монгол Улсын Шадар сайд
3	Хөрөнгө оруулалтын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар олон нийт, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	Монгол Улсын Шадар сайд
3	Хөрөнгө оруулагчид зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг сайжруулах	2026 оны 12 дугаар сар	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
3	Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэл хөтлөх журамд өөрчлөлт оруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2026 оны 09 дүгээр сар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаадын иргэн, харьяатын газар, Татварын ерөнхий газар, холбогдох яамд
3	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу зарим хураамжийн хэмжээг холбогдох цахим системд шинэчлэн тусгаж, нийтэд мэдээлэх	2026 оны 8 дугаар сар	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Холбогдох төрийн байгууллага